



АИХЭГ-ЫН СОНГУУЛЬ АЖИГЛАХ ТУСГАЙ ХОРОО Монгол Улс – Ерөнхийлөгчийн сонгууль, 2021 оны 6 дугаар сарын 9

УРЬДЧИЛСАН ҮР ДҮН, ДҮГНЭЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 6-р сарын 9-ний өдөр болсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль үр дүнтэй, ил тод зохион байгуулагдсан бөгөөд, КОВИД-19 цар тахал сонгууль зохион байгуулахад хүндрэл учруулж байсан боловч сонгууль эрхэлсэн байгууллагууд сонгогчдын оролцох бололцоог хангахад хүчин чармайлт гаргаж ажилласан. Эрх зүйн орчин ихээхэн зааварчилсан шинжтэй, эрх баригч нам давуу тал, нөөцөө ашиглаж байсан хэдий ч, нэр дэвшигчид сонгуулийн кампанит ажлаа чөлөөтэй явуулж чадлаа. Хууль эрх зүйн орчин нь сонгууль явуулах зохистой үндэс суурийг бий болгож буй боловч, нэр дэвших эрх ихээхэн хязгаарлагдмал, хэвлэл мэдээллийн харилцааг хэт зохицуулсан, сонгуультай холбоотой аливаа маргааныг шийдвэрлэхэд тогтоосон цаг хугацаа нь шүүхээр хамгаалуулах эрхийг хөндөж байна. Хэвлэл мэдээллийн байгууллагууд сонгогчдод сонгуулийн үйл ажиллагааны талаар мэдээлсэн боловч олон нийтийн өмнө мэтгэлцээгүй, төлбөрт нэвтрүүлгээс өөр нэр дэвшигчдийн талаар хараат бус мэдээлэл авах боломж хомс байсан зэрэг нь сонгогчид мэдээлэлд суурилж сонголт хийх бололцоонд нөлөөлж байлаа. Зарим санал авах байранд очиж ажиглалт хийхэд сонгууль маш сайн зохион байгуулалттай өрнөж байсан юм.

Улс төрийн нөхцөл байдал

2021 оны 1-р сарын 20-ны өдөр Улсын Их Хурлаас Ерөнхийлөгчийн сонгуулийг 2021 оны 6-р сарын 9-ний өдөр товлон. Найм дахь удаагийн ерөнхийлөгчийн сонгууль нь 2019 онд Үндсэн хуулийн шинэчлэлээр ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарлаж, ерөнхийлөгчийн албыг нэг удаа 6 жилийн хугацаатай болгож өөрчилснөөс хойш зохион байгуулж буй анхны сонгууль юм. Энэ удаагийн сонгууль 2020 оны УИХ-ын болон орон нутгийн сонгуульд эрх баригч Монгол Ардын Нам (МАН) олонхын саналыг авч, УИХ болон ихэнх аймаг, орон нутгийн засаг захиргаанд эрх мэдлээ хэрэгжүүлж буй үед зохион байгуулагдаж байна.¹ Энэ удаагийн сонгууль КОВИД-19 цар тахлын тохиолдол улс орон даяар, ялангуяа Улаанбаатар хотод ихсэж буй үед зохион байгуулагдаж байгаа нь сонгууль зохион байгуулах байгууллага болон нэр дэвшигчдийн кампанит ажилд зарим сорилтыг учруулж байна.

2011 онд хуваагдсан МАН, Монгол ардын хувьсгалт нам (МАХН) нэгдсэнээр МАН Ерөнхий сайд асан, одоогийн намын дарга Ухнаагийн Хүрэлсүхийг нэр дэвшигчээр тодруулав. Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа сонгох талаарх заалтад үндэслэн Үндсэн хуулийн цэц (ҮХЦ) 2021 оны 4-р сарын 16-ны өдөр дүгнэлт гаргасан нь сөрөг хүчин Ардчилсан нам (АН)-аас сонгогдсон одоогийн Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга дахин нэр дэвших боломжгүй байдал руу хөтөлсөн

¹ 2020 оны УИХ-ын сонгуульд МАН 62 суудал, Ардчилсан нам (АН) - 11 суудал, Хөдөлмөрийн Үндэсний Нам, Монголын Социал Демократ нам, Зүй ёс намын “Зөв Хүн Электорат Эвсэл” - 1 суудал, Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН) - 1 суудал авсан. Бие даан нэр дэвшигч нэг суудал авсан боловч 2021 оны 4-р сард УИХ дахь АН-ын бүлэгт элсжээ.

байна.² АН удирдлагын төлөө хоёр хэсэгт хуваагдан, дотооддоо зөрчилтэй байсаар сонгууль хүргэсэн бөгөөд хоёр талын аль аль нь Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ)-нд нэр дэвшигчээ бүртгүүлэх хүсэлт хүргүүлжээ. Тавдугаар сарын 3-ны өдөр Улсын дээд шүүх 2017 онд АН-ын даргаар Содномзундуйн Эрдэнэ сонгогдсон нь өнөөг хүртэл хүчинтэй байгаа хэмээн баталгаажуулснаар СЕХ түүнийг Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихийг зөвшөөрсөн. Зөв хүн электорат эвсэл (ЗХЭЭ) 2020 онд УИХ-д суудалтай болсноор Ерөнхийлөгчийн сонгуульд анх удаа оролцож буй бөгөөд УИХ-ын гишүүн асан Дангаасүрэнгийн Энхбатыг нэр дэвшигчээр тодруулжээ.

Хууль, эрх зүйн орчин ба сонгуулийн тогтолцоо

Сонгуулийн хууль, эрх зүйн орчин ерөнхийдөө ардчилсан сонгууль зохион байгуулахад хангалттай, иж бүрэн зохицуулалттай байна.³ 2017 оны буюу өмнөх Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулснаас хойш хууль, тогтоомжид томоохон өөрчлөлт орсон хэдий ч АИХЭГ-аас гаргасан хэд хэдэн зөвлөмжийг тусгаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2019 оны 11 дүгээр сард батлахдаа Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно гэж заасан нь одоогийн ерөнхийлөгч нэр дэвших эрхгүй болгожээ. Түүнчлэн насны шалгуур 45 нас байсныг 50 болгож нэмсэн, улс төрийн нам шинээр бүртгүүлэхэд шаардлагатай гишүүнчлэлийн тоо (нийт сонгогчдын 1 хувь)-г заасан ба сонгуулийн хууль, тогтоомжид ээлжит сонгуулиас нэг жилийн өмнө нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглосон заалтуудыг хуульчилсан байна.

Монгол Улсын Их Хурал 2020 оны 12-р сард Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг баталсан.⁴ АИХЭГ-ын САТХ-ны уулзсан төлөөлөгчид уг хуулийн хэлэлцүүлгийг оролцооны аргад тулгуурлан зохион байгуулсан боловч нэмэлт шинэчлэл шаардлагатай болохыг тэмдэглэсэн. Шинэчлэн баталсан уг хуульд сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа мэдээллийг иргэд баталгаажуулах боломжийг нэмэгдүүлэх, нэр дэвшигчэд тавьж буй тодорхой хязгаарлалтуудыг хүчингүй болгох зэрэг АИХЭГ-ын зарим зөвлөмжүүдийг тусгасан байна. Харин УИХ-д суудалгүй улс төрийн нам нэр дэвшүүлэх эрхтэй байх, бие даан нэрээ дэвшүүлэх эрхтэй байх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуульд оролцох эрх зүйн орчин хязгаарлагдмал, гомдол, маргаан хянан шийдвэрлэж буй ялгамжтай хугацаа, сонгуулийн нэг ба хоёр дахь шатны санал хураалтын хооронд сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглосон зохицуулалт, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин

² Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль Үндсэн хуульд заасан зөвхөн нэг удаа гэх хуулийн зохицуулалттай нийцэхгүй байна гэж дүгнэлт гаргасныг улмаар УИХ Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг хүлээн авсан тогтоол гаргасан. 4-р сарын 19-ний өдөр Ерөнхийлөгч Баттулга “төрийн эрх мэдлийг үндсэн хуулийн бус аргаар булаан авах” оролдлого хийсэн тул МАН-ыг татан буулгах тухай шийдвэрийг Улсын дээд шүүхэд хүргүүлжээ.

³ Холбогдох хууль, эрх зүйн баримт бичигт 1992 оны Үндсэн Хууль (сүүлд 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан), 2020 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, 2006 оны Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, 2011 оны Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль болон 2005 оны Улс төрийн намын тухай хууль тус тус багтсан болно (сүүлд 2020 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан). Үүн дээр 2016 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 оны Эрүүгийн хууль, 2017 оны Зөрчлийн тухай хууль, 2006 оны Авлигын эсрэг хууль болон 2016 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль тус тус нэмэгдсэн болно.

⁴ Улсын Их Хурал 2018 онд Сонгуулийн тухай хуулийг салган, Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулиудыг тус тусад нь боловсруулах үйл явцыг эхлүүлсэн.

тодорхой бус, мөн сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийн хяналт хангалтгүй байгаатай холбоотой бусад зөвлөмжүүдийг орхигдуулсан хэвээр байна.

Ерөнхийлөгч нь улсын хэмжээнд сонгуулийн нэг тойргоос шууд сонгох эрхийн үндсэн дээр сонгогдоно. Нэр дэвшигчдийн хэн нь ч олонхын санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг 14 хоногийн дотор хоёр дахь санал хураалтад оруулна. Хоёр дахь санал хураалтаар нэр дэвшигчдийн хэн нь ч олонхын санал аваагүй тохиолдолд дахин сонгууль явуулна. Нэг ч нэр дэвшигчийн төлөө санал өгөөгүй, тэмдэглээгүй саналыг Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн дагуу хүчинтэй саналын хуудсанд тооцогдоно гэж заасан. Тэмлэглээгүй санал нь үлдсэн хоёр нэр дэвшигчийг олонхын санал авахгүйд хүргэх хэмжээний их бол дахин сонгууль явуулах нөхцөлийг бүрдүүлж байна. Мөн Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн нийт сонгогчийн 50 хувь нь санал хураалтад оролцсоноор сонгуулийг хүчинтэйд тооцно. Уг хуулиар ирц хүрэхгүй бол 50 хувь нь оролцоогүй хэсэг тус бүрд нэмэлт санал хураалт явуулна. Хүний тэгш сонгох эрх, зохион байгуулалттай холбоотой бэрхшээл болон жижиг суурин газруудад саналын нууцлалыг алдагдуулах магадлалтай тул АИХЭГ-аас өмнө нь энэхүү ирцийн босго хувийг шүүмжилж байсан.

Сонгуулийн байгууллага

Сонгуулийг Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ) болон салбар хороод удирдан зохион байгуулав.⁵ СЕХ нь байнгын ажиллагаатай төрийн байгууллага бөгөөд зургаан жилийн хугацаатай томилогдсон есөн гишүүний бүрэлдэхүүнтэй.⁶ СЕХ-ны бүрэлдэхүүний зөвхөн нэг нь эмэгтэй гишүүн боловч сонгуулийн доод шатны хороодод эмэгтэйчүүдийн төлөөлөл сайн байлаа. Доод шатны бүх сонгуулийн хороод нь түр байгуулагддаг бүтэц бөгөөд бүрэлдэхүүнийг шинээр томилохдоо бэлтгэгдсэн, гэрчилгээ авсан, мэргэшсэн төрийн албан хаагчдын мэдээллийн сангаас гишүүдээ сонгон шалгаруулжээ. АИХЭГ-ын өмнөх зөвлөмжийн дагуу доод шатны сонгуулийн хороодод гарч болзошгүй гажуудлыг арилгахын тулд СЕХ-ноос хороодын гишүүдийг сонгон шалгаруулахдаа өмнөх туршлага, мэргэжлийн ёс зүйн хувьд цэвэр намтартай байх, төрийн албанд ажилласан жил зэрэг нэмэлт шалгууруудыг тогтоожээ. АИХЭГ-ын САТХ-ны уулзсан төлөөлөгчдийн дийлэнх нь сонгуулийн байгууллагын мэргэжлийн ерөнхий чадавх, шударга үнэн байдалд итгэж буйгаа илэрхийлэв.

Сонгуулийн байгууллага нь сонгуулийн бэлтгэлд хамаарах техникийн ажлуудыг үр дүнтэй, мэргэжлийн өндөр түвшинд удирдаж, хуулийн хугацааг мөрдөж ажиллалаа. СЕХ нь ээлжит хуралдаануудыг хийж, цар тахалтай холбоотой хорио хязгаарлалтын улмаас ихэвчлэн цахим хурлын платформ ашиглан зохион байгуулав. Ихэнх шийдвэр, журмууд нь СЕХ-ны вэбсайт дээр цаг тухайд нь нийтлэгдэж байсан нь ажлынх нь ил тод байдлыг хангахад хувь нэмэр оруулсан боловч хуралдааны тов, хэлэлцэх асуудлуудаа урьдчилан зарласангүй. СЕХ нь олон нийтийн болон

⁵ Үүнд аймаг, нийслэлийн сонгуулийн хороо (АНСХ) 22, сум дүүргийн сонгуулийн хороо (СДСХ) 339, сонгуулийн хэсгийн хороо (СХХ) 2087 тус тус багтана. Гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагаанд зориулж Гадаад Хэргийн Яамны дэргэд Төв комисс, мөн гадаадын 30 улсад суугаа дипломат төлөөлөгчийн газарт 44 салбар комисс байгуулагдсан.

⁶ Хорооны таван гишүүнийг Төрийн байгуулалтын байнгын хорооны санал болгосноор УИХ, хоёрыг Ерөнхийлөгч, хоёрыг Дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас томилдог. СЕХ-ны орон тооны гишүүд болох дарга, нарийн бичгийн даргыг УИХ-ын даргын санал болгосноор сонгодог. Хорооны бусад гишүүн нь орон тооны бус байна.

хувийн өргөн нэвтрүүлгийн сувгууд, олон нийтийн сүлжээний платформоор дамжуулан үйл ажиллагааныхаа талаар олон нийтэд идэвхтэй мэдээлж байсан нь сайшаалтай байлаа.

Засгийн газраас СЕХ болон Улсын онцгой комисстой хамтран сонгуулийн үеэр КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журмыг баталсан ба уг журмаар хувийн хамгаалалтын хэрэгсэл ашиглах, хүн хоорондын зай барих, сурталчилгааны ажилд тавигдах шаардлагууд, санал авах байранд нэмэлт зохицуулалт хийх, цар тахалд өртсөн сонгогчдыг хэрхэх талаар зохицуулжээ. Санал хураалт болохоос нэг өдрийн өмнө буюу 6-р сарын 8-ны өдөр зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авах ажил явагдаж, гэрийн тусгаарлалт, тусгаарлан ажиглах байр, мөн эмнэлгийн байгууллагуудад эмчлүүлж байгаа 7051 иргэн болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх эрх бүхий 18568 сонгогч саналаа өглөө.⁷ Шинжилгээний хариу нь эерэг гарсан болон хуульд заасан хугацаанаас хойш гэрийн тусгаарлалтад байгаа, мөн хөл хорионд орсон сонгогчид санал өгөх боломжгүй байв.

2012 оноос хойш сонгуулийн бүх хэсгийн хороо нь санал тоолох төхөөрөмж (СТТ)-өөр тоноглогдсон. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар бүх санал авах байранд нэмэлтээр хяналтын тооллого хийхээр заажээ. Уг хуульд санал тоолох төхөөрөмжийн үр дүнг албан ёсных гэж заасан боловч СТТ болон хяналтын тооллогын хооронд зөрүү гарч болох тохиолдлыг авч үзээгүй байна. СЕХ нь санал тоолох технологийн талаарх ил тод байдал, олон нийтийн ойлголтыг дээшлүүлэхийн тулд нэр дэвшигч, иргэний нийгмийн төлөөллийг байлцуулан төхөөрөмжийг хэд хэдэн шатанд туршиж үзсэн. Эдгээр төлөөлөгчид нь бие даан туршилт хийх эрхтэй байсан бөгөөд тэднийг ерөнхийлөгчийн сонгуулийн эх код болон системийн тохируулгыг дэлгэцэн дээр үзэхийг урьсан боловч техникийн баримт бичигтэй шууд танилцах эрх олгоогүй. АИХЭГ-аас өгсөн өмнөх зөвлөмж байгаа ч, төхөөрөмжийг бие даан шалгаж баталгаажуулахыг хуулиар шаарддаггүй. Хэдийгээр цөөн тооны улс төрч төхөөрөмжийн үнэн зөвд эргэлзэж байсан ч АИХЭГ-ын САТХ-ны гишүүдтэй уулзсан хүмүүс СТТ-д итгэж байгаагаа илэрхийлэв.

Иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-ууд нь сонгогчдын боловсролд, тэр дундаа залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан материал бэлтгэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан. СЕХ нь хэд хэдэн ИНБ-уудтай нягт хамтран ажиллаж, сонгуулийн мэдээллийн хүртээмжийг сайжруулахад, тухайлбал өөрийн вэбсайт дээрх бичвэрийн тохиргоог хийх, хэвлэмэл материалын аудио хувилбар буюу брайль үсгээр хэвлэх, сонгогчдын боловсролд зориулсан видео бичлэгүүддээ хадмал орчуулга оруулах, дохионы хэлний орчуулга ашиглах зэргээр хүчин чармайлт гаргалаа. Түүнчлэн СЕХ нь Сонгогчдын боловсрол төв ТББ-тай хамтран сонгуулийн гарын авлагыг монгол болон казак хэл дээр хэвлүүлжээ.

Сонгогчдын бүртгэл

Сонгуулийн өдрөөр 18 нас хүрсэн иргэд санал өгөх эрхтэй. Олон улсын өмнө хүлээсэн үүрэг болон АИХЭГ-ын өмнөх зөвлөмжүүдтэй зөрчилдөж, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль нь шүүхээр эрх зүйн чадамжгүй нь тогтоогдсон, оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй, үйлдсэн гэмт

⁷ Сонгогчид нь эрүүл мэндийн шалтгаанаар санал авах байранд өөрийн биеэр очиж санал өгөх боломжгүй, эсвэл хорих байгууллагад хоригдсоны улмаас, эсвэл сонгуулийн өдөр дайчлагдан ажиллаж буй төрийн албан хаагч гэсэн ангиллаас хамааран 6-р сарын 2, 5-ны дотор бүртгүүлэх боломжтой.

хэргийн ангиллаас үл хамааран хорих ял эдэлж буй хүмүүсийн санал өгөх эрхийг хязгаарласан заалтуудыг хэвээр үлдээжээ.⁸

Сонгогчдын нэрийн жагсаалтыг Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ)-ын иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд үндэслэн гаргасан бөгөөд уг санд иргэний хувийн болон биеийн давхцахгүй өгөгдлийг агуулдаг.⁹ Сонгогчийн мэдээллийг сонгуулийн өдөр санал авах байруудад сонгогчийн биеийн давхцахгүй өгөгдөл буюу хурууны хээ унших төхөөрөмжөөр баталгаажуулсан. Сонгогчдын нэрийн жагсаалтыг УБЕГ-ын цахим хуудсанд 4-р сарын 1-нд урьдчилсан байдлаар нийтлэв. Нэр дэвшигчид нь сонгогчдын нэрийн жагсаалтын нэгтгэсэн эцсийн хувилбарын цахим хуулбарыг санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө авах эрхтэй байсан бол, иргэний ажиглагчид сонгогчдын нэрийн жагсаалтыг зөвхөн сонгуулийн хэсгийн хороод дээр шалгах боломжтой байв. Сонгогчид өөрсдийн мэдээллээ баталгаажуулж болохын зэрэгцээ энэ удаагийн сонгуульд орсон нэг шинэ зүйл нь сонгогчид өөрсдийн хаяг дээр бүртгүүлсэн бүх хүний бүртгэлийг шалгаж нягтлах боломжтой байв. Сонгогчдын нэрийн жагсаалтыг цаасан хэлбэрээр 5-р сарын 15-ны дотор хүргүүлсний дараа бүртгэлийн мэдээллийг баталгаажуулах ажлыг сонгуулийн хэсгийн хороонд хийх боломжтой байснаас гадна 5-р сарын 26-ныг хүртэл өөрчлөлт оруулах хүсэлт гаргах боломжтой байв. Сонгогчид өөр санал авах байранд түр шилжүүлэх хүсэлт гаргаж болох боловч сонгогч бүртгэлээ бүртгүүлсэн хэсгийн хороо буюу шинэ хэсгийн хороондоо зөвхөн өөрийн биеэр хийх боломжтой байлаа. КОВИД-19 цар тахалтай холбоотой дотоодын шилижилт хөдөлгөөнийг хязгаарласан тул энэхүү зохицуулалт нь бүртгүүлсэн газраасаа хол байгаа, буцаж очих боломжгүй болсон ажилчид, оюутнууд саналаа өгөхөд хүндрэл бэрхшээл үүсгэсэн байна. Нийт 22,392 сонгогч бүртгэлээ түр шилжүүлэх хүсэлт гаргасан байна. Зургаадугаар сарын 5-наар хаагдсан сонгогчдын нэрийн эцэслэн гаргасан жагсаалтад 2,040,556 үндсэн сонгогч бүртгэгджээ.

АИХЭГ-ын САТХ-той уулзаж ярилцсан хүмүүс сонгогчдын нэрийн жагсаалт үнэн зөв байж, бүх сонгогчийг ялгаварлахгүйгээр хамруулсан гэдэгт илтгэж буйгаа илэрхийлсэн. Зарим хүмүүс үндэсний хаягжилтын бүртгэлийн системд олон жилийн турш явж ирсэн алдаа дутагдлыг онцолж, зарим нэг газарт эргэлзээ төрүүлэхүйц бүртгэлүүд илэрсэн ч гэлээ санаа зовоох гол шалтгаан биш гэлээ. Гэсэн хэдий ч сонгогчдын нэрийн жагсаалтын мэдээлэлтэй танилцахад тавьж буй хязгаарлалтууд нь хараат бус, бие даасан хяналт шалгалтыг хийх боломжийг хааж байв.

Нэр дэвшигчийн бүртгэл

Эрх бүхий нэр дэвшигч нь Монгол эцэг, эхтэй байх ёстой бөгөөд сонгууль болохоос өмнөх сүүлийн таваас доошгүй жил Монгол Улсад оршин суусан байна. Сүүлд хийгдсэн Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр насны шалгуурыг 45 нас байсныг 50 болгон нэмэгдүүлсэн. Эрх

⁸ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай 2013 оны конвенцийн Хорооны захидал харилцааны 4/2011 тоот хэсгийн 9.4-т “29-р зүйлд ямар нэгэн хязгаарлалтыг тавиагүйгээс гадна ямар ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүлэгт эрхийг нь хасахыг зөвшөөрөхгүй. Тиймээс сэтгэцийн болон оюуны бэрхшээлтэй гэж үзсэн, эсвэл бодит байдалд нь тулгуурлан санал өгөх эрхийг нь хасах, үүнд хувь хүний үнэлэмжийн дагуу хязгаарлалт хийх нь Конвенцийн 2-р зүйлд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй гэж ялгаварлан гадуурхах явдал юм” гэжээ. Түүнчлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын 2006 оны конвенцийн 12, 29-р зүйлийг үзнэ үү.

⁹ Гадаад улсад байгаа санал хураалтад оролцохыг хүссэн сонгогчид 4-р сарын 20-оос 5-р сарын 9-ний хооронд дипломат төлөөлөгчийн газарт бүртгүүлэх шаардлагатай байв. ГХЯ-ны мэдээлснээр 5-р сарын 30, 31-нд 7,394 сонгогч саналаа өгөхөөр бүртгүүлжээ.

бүхий нэр дэвшигч нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих өр төлбөр, зээл болон татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх ёстой. Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль нь авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн хүн нэр дэвшихийг хориглох зохицуулалт нэмсэн ба сэтгэцийн эмгэг, эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон хүн нэр дэвшихийг хориглосон заалт хэвээр үлдсэн байна. Өмнө нь өгч байсан АИХЭГ-ын зөвлөмжийн дагуу цэргийн албан хаагаагүй байх, ял шийтгүүлж байсан зэрэг нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах үндэслэл бүхий заалт, шаардлагуудыг шинэчлэн баталсан Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд оруулаагүй байна. Хэдийгээр зөвлөмжийг тусгасан ч, шаардлага нь ерөнхийдөө ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтууд болон олон улсын бусад хэм хэмжээтэй зөрчилдсөн, хязгаарлагдмал байна.

Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн дагуу парламентад суудалтай улс төрийн намууд нэр дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс 40 хоногийн өмнө эхлүүлж, гурав хоногийн хугацаа (4-р сарын 30-наас 5-р сарын 2 хүртэл)-нд дуусгах ба, үүний дараа СЕХ бүртгэх эсэх асуудлыг гурав хоногийн дотор шийдвэрлэнэ. Нэр дэвшигчийг бүртгэх хугацаа богино төдийгүй сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарьт харьцангуй хойно байгаа асуудлыг АИХЭГ өмнө нь хөндөж байсан ба нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан тохиолдолд шүүхээр хамгаалуулах эрхийг хөндөж байна. (Гомдол, маргаан хэсгийг харна уу). СЕХ нь нэр дэвшүүлсэн дөрвөн хүнээс гурвыг нь 5-р сарын 7-ны өдөр бүртгэсэн ба бүгд эрэгтэй байна.¹⁰ АИХЭГ-аас УИХ-д суудалгүй нам болон хувь хүн бие даан нэр дэвших боломжийг олгох тухай зөвлөмж өмнө нь гаргаж байсан. Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтууд болон олон улсын бусад хэм хэмжээтэй нийцэхгүй, сонгогчдын сонголтыг хязгаарлаж байна.¹¹

Нэр дэвшигчээр бүртгүүлэхийн тулд эрх бүхий нэр дэвшигч мөрийн хөтөлбөрөө Үндэсний аудитын газар (ҮАГ)-т хүргүүлэн улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтөд нийцсэн эсэхийг хянуулна. Сонгуулийн сурталчилгаа эхлэхийн өмнө нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрт хийсэн дүгнэлтээ ҮАГ өөрийн цахим хуудаснаа байрлуулсан байна. Энэ удаагийн сонгуульд тохиолдоогүй ч хуульд заасан зохицуулалтаар ҮАГ-ын дүгнэлтийн дагуу СЕХ-нд нэр дэвшигчийг хасах хүртэл шийдвэр гаргах эрх олгосон. Энэ журам нь иргэний нэр дэвших эрх болон сонгуулийн сурталчилгаа хийх эрх чөлөөнд саад болох магадлалтай юм.¹²

¹⁰ АН-ын хоёр фракц тус тусдаа ерөнхийлөгчид нэр дэвшигчээ дэвшүүлэв. СЕХ нь Улсын дээд үзэх, УБЕГ-аас ирүүлсэн мэдээллийг үндэслэн Норовын Алтанхуягийн ирүүлсэн материалыг харгалзаж үзээгүй талаар АИХЭГ-ын САТХ-нд мэдээлсэн.

¹¹ [Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт \(ИУТЭОУП\)-ын 25 дугаар зүйлд өгсөн 1996 оны НҮБ-ын Хүний эрхийн хорооны 25 дахь санал](#)-ын 15 дугаар догол мөрд “боловсрол, оршин суугаа газар эсхүл гарал үүсэл, улс төрийн хамаарал зэрэг үндэслэлгүй эсхүл ялгавралан гадуурхасан шаардлагыг тавьж сонгуульд нэр дэвших боломжтой хүнийг хасах ёсгүй” гэж заасан байдаг. 1990 оны ЕАБХАБ-ын Копенгагены баримт бичгийн 7.5 дахь хэсэгт “улс төрийн болон төрийн албан тушаал дангаараа болон улс төрийн нам, байгууллагын төлөөллөөр дамжуулан хаших эрхийг ялгаварлан гадуурхагдалгүйгээр хүндэтгэх” ёстой хэмээн заасан байна. Мөн 1990 оны ЕАБХАБ-ын Копенгагены баримт бичгийн 24 дэх хэсэг, 2002 оны Венецийн комиссийн Сонгуультай холбоотой сайн туршлагын дүрмийн II.1.b хэсгийг харна уу.

¹² ИУТЭОУП-ын 2017 онд хийсэн Монгол Улсад хийсэн ажиглалтын дүгнэлтийн 39 дүгээр хэсэгт “Үндэсний аудитын газар аливаа нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны тодорхой хэсгийг баглахгүй байх эрхтэй” тул сонгуулийн сурталчилгаа хийх эрх чөлөөтэй холбоотой асуудлыг хөндсөн.

Сонгуулийн сурталчилгаа

Сонгуулийн сурталчилгаа албан ёсоор 5-р сарын 24-ны өдрөөс 6-р сарын 7-ны өдрийн хооронд болж өнгөрлөө. Арван ес хоногийн турш үргэлжилж байсан ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны хугацааг шинэчлэн батлагдсан Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар 15 болгон богиносгосон нь цар тахлын улмаас аль хэдийнээ хумигдаад байсан сонгогчиддоо хүрч ажиллах боломжийг улам хязгаарласан алхам болсон гэж зарим улс төрийн намууд тэмдэглэв. Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль нь нэр дэвшигчид сонгуулийн кампанит ажлаа хэрхэн зохион байгуулах, сурталчилгаанд ашиглах материал, хөрөнгө, сонгуулийн штабын хэлбэр, хэмжээг хатуу тогтоож, зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг жагсааж өгсөн зэргээр ерөнхийдөө зааварласан шинжтэй байна. Сонгогчдод мөнгө болон эд зүйл тараах, олон нийтийг хамарсан үзвэр, урлагийн тоглолтын үеэр сонгуультай холбоотой сурталчилгаа явуулах зэргийг хуулиар хоригложээ. Түүнчлэн сонгуулийн жилд (санал авах өдрөөс өмнө) олон нийтийн санаа бодлын судалгааг хэвлэн нийтлэх, сонгуульд оролцохгүй байхыг уриалах зэргийг хуулиар хориглодог.

Сонгуулийн сурталчилгаа ерөнхийдөө даруухан болж өндөрлөсөн хэдий ч нөөцийн харилцан адилгүй байдал ажиглагдав. Бүх нэр дэвшигчид ямар нэг хөндлөнгийн оролцоогүйгээр сурталчилгаагаа чөлөөтэй явуулах боломжтой байв. Нэр дэвшигчид зарим олон нийтийг хамарсан уулзалт, сонгуулийн арга хэмжээг зохион байгуулсан боловч ерөнхийдөө аль болох сонгогчидтой шууд харилцахгүй байх, цахим сүлжээ, ялангуяа Фэйсбүүк ашиглан сурталчилгаагаа явуулахыг зорьж байлаа. АИХЭГ-ын САТХ-ны ажигласнаар сурталчилгааны арга хэмжээнүүд хуульд заасан шаардлагын дагуу дохионы хэлний хэлмэрчтэй явагдсан. Сонгуулийн сурталчилгаанд эмэгтэйчүүдийн оролцоо хязгаарлагдмал төдийгүй нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрт эмэгтэй сонгогчдын саналыг татах заалт бараг л байсангүй. Түүнчлэн гадаад бодлогын болон шүүх эрх мэдэлтэй холбоотой ерөнхийлөгчийн бүрэн эрхийн асуудлаас гадна бүх нэр дэвшигчид ерөнхийлөгчийн бүрэн эрхээс давсан эдийн засаг, хөрөнгө оруулалт, уул уурхайн нөөц, нийгмийн халамж болон цар тахалтай холбоотой асуудлаар давтамжтай сурталчилгаа явуулж байсан. Сонгууль болохоос 4 хоногийн өмнө ЗХЭЭ-ээс нэр дэвшигч Д.Энхбат КОВИД-19 өвчнөөр өвдсөн тухайгаа зарласнаар түүний сурталчилгааны үйл ажиллагаанууд зогссон.

Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах асуудлыг зохицуулсан бөгөөд хяналт тавих эрхийг хэд хэдэн байгууллагууд хамтран хэрэгжүүлэхээр тусгажээ. Нэг нэр дэвшигч цахим орчинд сурталчилгаа явуулах дээд тал нь нэг цахим хуудас, олон нийтийн сүлжээний нэг хаягтай байхыг хуулиар зөвшөөрчээ. Энэхүү хязгаарлалтын зорилго нь тодорхойгүй бөгөөд АИХЭГ-ын САТХ-ны ажигласнаар нэр дэвшигч бүрийг дэмжсэн хэд хэдэн Фэйсбүүк хуудас байсан төдийгүй зарим нь төлбөртэй улс төрийн сурталчилгаа явуулж байсан. Харилцаа Холбооны Зохицуулах Хороо (ХХЗХ) цахим талбар дахь сонгуультай холбоотой контентод хяналт тавихаар Фэйсбүүктэй хамтын ажиллагаа эхлүүлсэн боловч энэхүү хамтын ажиллагааны нөхцөл, боломжит ямар арга хэлбэрээр ажиллах талаар олон нийтэд мэдэгдээгүй юм.

АИХЭГ-ын САТХ-ны ажигласнаар АН, ялангуяа МАН-ын сонгуулийн сурталчилгааг төрийн албан хаагчид дэмжсэн хэд хэдэн тохиолдол гарсан. АИХЭГ-ын САТХ-той ярилцсан зарим хүмүүс төрийн албан хаагчид, төрийн албаны нөөцийг сонгуулийн сурталчилгаанд буруугаар ашиглах нь эрх баригч намд давуу байдал үүсгэх асуудалд санаа зовниж буйгаа илэрхийлсэн юм. Зарим нь

сонгуулийн санал худалдаж авах ажиллагаа, ялангуяа хөдөө орон нутагт тасралтгүй үргэлжилж буй тухай асуудлыг ч тавьж байлаа. Сонгууль болохоос хэдхэн сарын өмнө Засгийн газар КОВИД-19 цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлсэн нөлөөг саармагжуулах зорилгоор нийгмийн ялгаатай бүлгүүдэд татаас болон бусад тэтгэмж олгох томоохон хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн.¹³

Сонгуулийн санхүүжилт

Сонгуулийн санхүүжилтийн тайлан илгээх үйл явц тодорхой хэмжээнд сайжирсан боловч санхүүжилтийн ерөнхий тогтолцоонд хяналт, ил тод байдлыг хангалттай зохицуулаагүй нь сонгогчид нэр дэвшигчдийн орлогын эх үүсвэрийн талаарх мэдээлэл авах бололцоог хязгаарлаж байна.

Нэр дэвшигчид сурталчилгаагаа хувь хүн (3 сая хүртэл), хуулийн этгээд (15 сая хүртэл)-ийн хандиваар, нэр дэвшүүлсэн намын хөрөнгөөр санхүүжүүлэхээс гадна өөрөөсөө санхүүжүүлж болно.¹⁴ Гадаадын болон бэлэн мөнгөний хандив өгөхийг хориглоно. ҮАГ нь энэ удаагийн сонгуулийн санхүүжилтэд хяналт тавих үүрэгтэй үндсэн байгууллага бөгөөд намын сонгуулийн сурталчилгааны бүх гүйлгээ ҮАГ-т бүртгэгдсэн дансаар хийгдэх ёстой. ҮАГ-аас энэ сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоосон ба нэг нэр дэвшигчид ойролцоогоор 8.1 тэрбум төгрөг байхаар заажээ.¹⁵ Цугларсан санхүүжилтийг дараагийн сонгууль руу шилжүүлэхийг зөвшөөрсөн заалт, мөн зарцуулж болох зардлын дээд хэмжээг зааж өгсөн нь олон жил болсон улс төрийн намуудад давуу талыг бий болгож болзошгүй юм.

ҮАГ-аас намуудад санхүүгийн тайлангаа гаргаж өгөх онлайн платформ, тайлангийн загварыг танилцуулсан нь сайшаалтай байлаа. Тайланг эхлээд тухайн намын сонгосон хувийн аудитын байгууллагаар хянуулах ёстой бөгөөд сонгууль болсноос хойш 45 хоногийн дотор ирүүлэх ёстой. АИХЭГ өмнө нь зөвлөмж өгсөн боловч намууд санхүүгийн явцын тайланг илгээх, нийтлэх үүрэг хүлээхгүй байгаа нь сонгуулийн өдрийг хүртэлх сурталчилгааны ажлын санхүүжилт ил тод байх явдлыг хязгаарлаж байна.¹⁶

Хэдийгээр Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар сонгуулийн сурталчилгааны үеэр хяналт тавих, нэр дэвшигчдийн сонгуулийн санхүүжилттэй холбоотойгоор газар дээр нь мэдээлэл цуглуулах бусад арга хэрэгслийг зохицуулсан боловч ҮАГ эдгээр хяналтыг хэрэгжүүлээгүй. Тиймээс сонгуулийн санхүүжилтийн бүх зардал, бэлэн бус хандивыг санхүүгийн тайланд оруулсан эсэхийг баталгаажуулах боломжгүй юм. Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар аудит хийгдсэн эцсийн тайланг хянаж, үнэлгээнийхээ үр дүнг 60 хоногийн дотор нийтлэх үүргийг ҮАГ-т олгосон. Гэсэн хэдий ч, уг хуулиар ҮАГ-т санхүүгийн тайланг хэвлэн нийтлэх үүрэг хүлээх тухай

¹³ 2020 оны 4-р сарын 13-ны өдөр УИХ ажилгүйдлийн тэтгэмж, хүүхдийн мөнгө, тэтгэврийн зээл тэглэх, импортын зарим барааг татвараас чөлөөлөх болон бусад нийгмийн халамжийн чиглэлийн үйл ажиллагаа зэргээр цар тахлын эсрэг хэд хэдэн арга хэмжээг баталсан. Засгийн газар 2020 оны 12-р сараас 2021 оны 7-р сар хүртэл сайжруулсан түлшний хөнгөлөлтийг нэмэгдүүлж, айл өрхийн цахилгаан, дулаан, ус, хогны төлбөрийг чөлөөлжээ.

¹⁴ Нэг евро нь ойролцоогоор 3,450 монгол төгрөгтэй тэнцдэг.

¹⁵ 2.3 сая орчим евро.

¹⁶ НҮБ-ын Авлигын эсрэг 2003 оны конвенцийн 7.3-т “Оролцогч улс орнууд нь төрийн албанд нэр дэвшигчдийн анхүүжилт, шаардлагатай тохиолдолд улс төрийн намуудын санхүүжилтийн ил тод байдлыг дээшлүүлэх чиглэлээр хууль тогтоомжийн болон захиргааны зохих арга хэмжээг авах талаар авч үзнэ” гэж заасан.

зааж өгөөгүйгээс гадна үнэлгээг ямар хэмжээнд нарийвчлан гаргах тухай тодорхой тусгаагүй нь ил тод байдлыг хангалттай баталгаажуулж чадахгүйд хүргэж байна.

Хэвлэл мэдээлэл

Хэвлэл мэдээллийн орчин маш идэвхтэй боловч хязгаарлагдмал зах зээлд 500 орчим хэвлэл мэдээллийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас ихэнх нь санхүүгийн хувьд бие даах боломжгүй байна. Үүнтэй холбогдуулан маш олон хэвлэл мэдээллийн байгууллага улс төрийн сонирхол бүхий эзэмшигчээсээ хамааралтай байдаг ба редакцын мэдээ, мэдээллээ арилжаалах хандлагатай байдаг тухай АИХЭГ-ын САТХ-той уулзаж ярилцсан хүмүүс дурджээ. Интернэтийн өргөн хүртээмжийн ачаар олон нийтийн сүлжээ, ялангуяа Фэйсбүүк нь телевизтэй дүйцэхүйц мэдээлэл авах үндсэн эх сурвалж болж байна.

Үндсэн хуулиар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангахын зэрэгцээ бусад хууль тогтоомжоор хэвлэл мэдээллийн зохистой эрх зүйн орчинг бүрдүүлсэн.¹⁷ Хэдийгээр 2017 онд гутаан доромжлохыг гэмт хэрэгт тооцохоо больсон боловч хүнд шийтгэл бүхий “худал мэдээлэл”, гүтгэлэгтэй холбоотой зүйл заалтууд зарим хуульд хадгалагдаж хэд хэдэн хуульд шинээр нэмэгдсэн.¹⁸ Эдгээр заалт нь сэтгүүлчид өөрсдөдөө цензур тавихад хүргэдэг талаар АИХЭГ-ын САТХ-той уулзсан зарим хүмүүс тэмдэглэсэн байна.

Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар сонгуулийн сурталчилгаанд хамаарах ёс зүйн байдал болон радио телевиз интернэтэд цацах үйл явцыг зохицуулсан. Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз (МҮОНРТ) нэвтрүүлгээ үнэгүй цацах боломжийг нэр дэвшигчдэд олгох үүрэгтэй бөгөөд хувийн телевизүүдийг улс төрийн нэвтрүүлгийг тогтоосон хязгаарын хүрээнд төлбөртэй дамжуулахыг зөвшөөрдөг.¹⁹ Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар нэг нэр дэвшигчийн талаарх мэдээг хоногт таван минутаас ихгүй байхаар тогтоосон нь телевизийн редакцын эрх чөлөөг хязгаарлаж байна. Сонгуулийн сурталчилгааны үеэр цахим орчин ашиглах тухай Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн зохицуулалт нь хэт хязгаарласан шинжтэйгээс гадна үр дүн багатай байна.²⁰ Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар ХХЗХ-нд цахим мэдээллийн хэрэгсэл болон телевиз, радиогийн эрхийг шүүхийн тайлбаргүйгээр цуцлах зэргээр эрх мэдлийг өргөн хүрээнд олгож буй нь олон улсын жишигт нийцэхгүй байна.²¹ Өргөн нэвтрүүлгийн болон цахим мэдээллийн хэрэгсэлд тавих хяналтыг СЕХ, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар болон ХХЗХ гэх мэт хэд хэдэн байгууллага хуваан хэрэгжүүлэх бөгөөд ХХЗХ голлох үүрэг хүлээдэг.

¹⁷ 2001 онд батлагдсан Харилцаа холбооны тухай хууль, 1998 онд батлагдсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, 2005 онд батлагдсан Олон нийтийн радио, телевизийн тухай хууль, 2019 онд батлагдсан Өргөн нэвтрүүлгийн тухай хууль зэрэг хуулиудаар хэвлэл мэдээллийн салбарын харилцааг зохицуулж байна.

¹⁸ Эрүүгийн хууль (13.4, 14.8 дугаар зүйл), ЕСТХ (31.4 дүгээр зүйл), Коронавируст халдвар /КОВИД-19-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль (12.3, 13.3 дугаар зүйл)

¹⁹ МҮОНРТ нэг өдөрт 15 минутын эфирийн цагийг нэр дэвшигч бүрт олгох ба хувийн телевиз нэг өдөрт нэг нэр дэвшигчийн 15 минутаас илүүгүй төлбөрт нэвтрүүлгийг дамжуулж болно.

²⁰ Тухайлбал, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд мэдээний цахим хуудсууд сонгуулийн холбогдолтой мэдээ, нийтлэл нийтлэхдээ сэтгэгдэл бичих хэсгийг идэвхгүй болгох зохицуулалттай. Харин тэдгээр мэдээ, нийтлэл ижил хугацаанд Фэйсбүүк дээр нийтлэгдсэн тохиолдолд сэтгэгдлийн хэсэг нээлттэй байдаг.

²¹ НҮБ, ЕАБХАБ, Америкийн муж улсуудын байгууллага, Африкийн хүний болон ард түмний эрхийн комиссын 2020 оны [Дижитал эринд сонгуулийн үеэр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаар хамтарсан тунхаглал](#) үзнэ үү. Захиргааны шийдвэрийг шүүхээр хянах тухай ЕАБХАБ-ын болон Ерөнхий зарчмыг үзнэ үү.

Үүрэг, хариуцлагыг хувааж олгож буй нь Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн дагуу хэвлэл мэдээлэлтэй холбоотой гомдлыг үр дүнтэй шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлж байна.²²

ХХЗХ-ны мэдээлснээр ерөнхийдөө мэдээний болон төлбөртэй нэвтрүүлгийн хязгаартай заалтыг баримталсан ба олон нийтийн радио телевиз нь бүх нэр дэвшигчдэд үнэгүй эфирийн хугацаа олгосон. Хэвлэл мэдээллийн байгууллагууд сонгууль өгөх ажиллагааны талаар сонгогчдыг мэдээллээр хангахад хувь нэмэр оруулав. Гэсэн хэдий ч, иргэний нийгмийн байгууллагууд болон хэвлэл мэдээллийн салбарын уулзсан зарим хүмүүс нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг задлан шинжилж мэдээлэх, хэлэлцүүлэг зохион байгуулах хөтөлбөрүүд дутагдалтай байсныг мэдээлсэн юм. Үүний дээр, телевизийн сувгууд олон нийтэд бие даасан байр сууриас мэдээлэх үүргээ ихээхэн хэмжээгээр үл хэрэгсэн нам, нэр дэвшигчдийн бэлдсэн мэдээллийг мэдээний хөтөлбөрийн дундуур тогтмол цацаж, мэдээ болон улс төрийн сурталчилгааны зааг ялгааг бүдгэрүүлсэн гэдгийг дурдсан. Ерөнхийдөө, телевизүүд нэр дэвшигчдийн хувьд төлбөртэй улс төрийн нэвтрүүлгээ дамжуулах гол талбар болсон бөгөөд сонгуулийн талаарх хараат бус, бие даасан мэдээллийг маш бага түгээсэн. Сонгуулийн сурталчилгааны сүүлийн өдөр МҮОНТ-ээр дамжуулахаар товлогдож, хүмүүсийн дунд ихэд хүлээлт үүсгээд байсан нэр дэвшигчдийн хоорондын мэтгэлцээн нь талууд мэтгэлцээнийг ямар хэлбэрээр зохион байгуулах талаар нэгдсэн шийдэлд хүрээгүй, мөн нэр дэвшигч Д.Энхбатын КОВИД-19-ийн оноштой холбоотойгоор цуцлагдсан.

Гомдол, маргаан

Сонгуультай холбоотой зөрчил, төрийн захиргааны байгууллагын шийдвэрт гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх хэд хэдэн суваг байдаг боловч хугацааны хувьд уртасгасан бөгөөд сонгуулийн цаг хугацаатай нийцэхгүй байна. АИХЭГ-ын өмнөх тайлан, зөвлөмжид тусгасны дагуу гомдол, маргаан үүсгэн хэрэг хянан шийдвэрлэх хугацаа нь сонгуулийн цаг хугацаа, мөчлөгтэй нийцэхгүй байгаа бөгөөд шүүхээр эрхээ үр дүнтэй хамгаалахад саад болох магадлалтай байхын сацуу ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтууд болон олон улсын бусад хэм хэмжээтэй нийцэхгүй байна. Тухайлбал, нэр дэвшигчийн бүртгэлтэй холбоотой маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх болон Дээд шүүхээр хянан шийдвэрлэж дуусах хүртэл санал авах өдөр өнгөрөх боломжтой ба цаашлаад Ерөнхийлөгч тангараг өргөсний дараа ч үргэлжлэх магадлалтай.

Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн дагуу сонгуулийн хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан гомдлыг шатлан захирагдах зарчмаар дээд шатны сонгуулийн хороо нь хянан шийдвэрлэнэ. СЕХ-ны шийдвэрт долоо хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд нэхэмжлэл гаргах бөгөөд хэргийг 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх ба 10 хүртэлх хоногоор сунгах боломжтой. Энэхүү шүүхийн шийдвэрийг Дээд шүүхэд тав хоногийн дотор давж заалдах боломжтой бөгөөд Дээд шүүх сунгах эрхгүйгээр 21 хоногийн дотор хэргийг хянан шийдвэрлэнэ. Ардчилсан намын нэр дэвшигчээр горилогч Норовын Алтанхуяг өөрийг нь бүртгэхээс татгалзсан болон АН-аас нэр дэвшүүлсэн С.Эрдэнийг бүртгэсэн СЕХ-ны шийдвэрийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд тус тус нэхэмжлэл гаргасан. Шүүх түүний хоёр

²² АИХЭГ өмнө нь телевизийн сувгийг хянах үүрэг хариуцлагыг нэгтгэж нэг байгууллагад хариуцуулан хангалттай санхүү, хүний нөөц төсөвлөх тухай зөвлөмж гаргаж байсан.

нэхэмжлэлийг хоёуланг нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн бөгөөд тэрээр Дээд шүүхэд давж заалдах гомдол гаргаад байна.

Сонгуулийн холбогдолтой хэрэг, зөрчил хянан шийдвэрлэхэд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар зохицуулагдана. Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн дагуу санал худалдаж авах зэрэг зөрчлийг цагдаагийн байгууллага мөрдөн байцаалт явуулан шалгаад, гэмт хэргийн шинжтэй бол тагнуулын байгууллагад шилжүүлнэ. Сонгуулийн өмнөх өдөр цагдаагийн байгууллагад сонгуультай холбоотой нийт 41 гомдол ирснээс 19 гомдлыг шийдвэрлэсэн ба үлдсэн 22 гомдлыг санал авах өдрийн байдлаар шалган шийдвэрлээгүй байна.

Иргэд ба олон улсын ажиглагчид

Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар иргэд болон олон улсын ажиглагчид, мөн нэр дэвшигчдийн төлөөлөгчдөд сонгууль ажиглах чухал эрхийг олгосон нь сонгуулийн үйл явцын ил тод байдлыг сайжруулжээ. Ажиглагчид бүх шатны сонгуулийн хорооны хуралдаан, үйл ажиллагаатай танилцах, санал хураалтын явцыг видео, аудио бичлэгээр баримтжуулах, СТТ-ийн дүнгийн хэвлэмэл хуудас болон саналын хуудасны тоон зургийг авах боломжтой байв. Иргэний ажиглагчид тухай тухайн хэсгийн хороонд бүртгүүлэх шаардлагатай байсан бөгөөд шинэ хуулиар нэг хэсгийн хороонд хоёр хүртэлх ажиглагч томилж болно. Ажиглагч байгууллагуудын бүртгүүлэх хэсгийн хороодын тоог хязгаарлаагүй боловч төвлөрсөн бус бүртгэл нь дотоодын ажиглагчдыг хуваарилахад хүндрэл учруулж болзошгүй юм. СЕХ нь иргэний нийгмийн гурван байгууллагын 150 ажиглагч, олон улсын 83 ажиглагчид итгэмжлэл олгов. Түүнчлэн иргэний 4 ажиглагч, улс төрийн намын 14 ажиглагч гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг ажиглах итгэмжлэл авчээ.²³

Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн сүлжээ ТББ нь сонгогчдын бүртгэл, хэвлэл мэдээллийн мониторинг, сонгуулийн зардал, санал тоолох төхөөрөмж, санал авах өдрийн ажиллагааг хамарсан урт хугацааны ажиглалт хийжээ.²⁴ Монголын багш-эцэг эхийн холбооноос анх удаа сонгуулийн үйл явцын хүртээмжийг үнэлэх зорилгоор ажиглагчид, түүний дотор олон янзын хөгжлийн бэрхшээлтэй ажиглагчдыг ажиллуулав.

Сонгуулийн өдөр

АИХЭГ-ын САТХ нь сонгуулийн өдрийн үйл ажиллагааг иж бүрэн, системтэйгээр ажиглаагүй болно. Зарим санал авах байранд очиж ажиглалт хийхэд сонгууль маш сайн зохион байгуулалттай өрнөж байсан юм. СЕХ сонгуулийн өдөр болж буй үйл явдлын талаар тогтмол мэдээлэл өгч байсан нь сонгуулийн үйл явцын ил тод байдалд чухал хувь нэмэр оруулсан төдийгүй бүртгэлийн төхөөрөмжийн тусламжтайгаар сонгуулийн ирцийг насны бүлэг, хүйс, газар зүйн байршлаар задлан харуулсан мэдээллийг өөрсдийн цахим хуудсаар тасралтгүй дамжуулсан. Иргэний нийгмийн ажиглагчдын үйл ажиллагаа ерөнхийдөө саадгүй хэрэгждэг талаар АИХЭГ-ын САТХ-нд мэдээлсэн юм. Сонгуулийн өмнөх өдөр сурталчилгаа явуулаагүй боловч АИХЭГ-ын САТХ-нд улс төрийн намууд сонгогчидтой утсаар холбогсон тухай мэдээлэл ирсэн. Энэ нь сонгогчдын

²³ “Зөв Хүн Электорат” эвслээс ирүүлсэн өргөдлийг хоцорч ирүүлсэн гэж буцаасан.

²⁴ Энэхүү эвсэл нь Нээлттэй нийгэм форум, Глоб Интернэшнл, Монголын Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв, МИДАС, Бодлогод залуусын хяналт ТББ зэрэг байгууллагуудаас бүрддэг.

боловсролд төвийг сахих тухай шаардлага, сонгуулийн өмнөх өдөр аливаа сурталчилгаа явуулахгүй байх зэрэгт нөлөөлж буй үйлдэл юм. Санал тооллогын дараа СЕХ-ны мэдээлэлд үндэслэн аймаг бүрийн сонгуулийн урьдчилсан тоон мэдээг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өргөнөөр дамжуулав. СЕХ сонгуулийн дүнг санал авах байраар задлан харуулсангүй. Урьдчилсан байдлаар сонгуулийн ирцийг 59.2 хувь хэмээн зарлалаа.

*Энэхүү тайлангийн англи хэл дээрх хувилбар нь албан ёсны хувь болно.
Монгол хэл дээрх албан бус орчуулгыг авах боломжтой.*

ХОРООНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ, ТАЛАРХАЛ

Улаанбаатар хот, 2021 оны 6-р сарын 10 – Энэ удаагийн сонгууль ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтууд, ардчилсан сонгуультай холбогдох бусад олон улсын үүрэг, хэм хэмжээ болон дотоодын хууль тогтоомжуудтай нийцэж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор энэхүү үнэлгээг хийсэн болно.

АИХЭГ нь 2005 оны Олон улсын сонгуулийг ажиглах зарчмын тунхаглалыг хүлээн зөвшөөрдөг. Энэхүү Урьдчилсан үр дүн ба дүгнэлтийн тайлан нь сонгуулийн үйл явц бүрэн дуусахаас өмнө гарч байна. Энэ удаагийн сонгуулийн талаарх эцсийн үнэлгээ нь сонгуулийн үйл явцын үлдсэн үе шат хэрхэн өрнөх, тухайлбал санал тоолох, санал хураалтын дүнг нэгтгэх болон нийтэд зарлах, сонгуулийн дараа гарч болзошгүй гомдол, маргааныг хэрхэн шийдвэрлэх зэргээс хамаарна. АИХЭГ нь санал зөвлөмжүүдийг агуулсан дэлгэрэнгүй тайланг сонгуулийн үйл явц дууссанаас хойш найм орчим долоо хоногийн дараа гаргана.

АИХЭГ-ын САТХ нь 5-р сарын 21-ний өдрөөс ажиллаж эхэлсэн бөгөөд САТХ-ны тэргүүн нь хатагтай Лолита Сигане юм. АИХЭГ-ын САТХ нь 10 шинжээчийн бүрэлдэхүүнтэй Улаанбаатар хотноо ажиллаж байна. АИХЭГ-ын аргачлалын дагуу тус хорооны гишүүд Улаанбаатар хотод цөөн хэдэн санал авах байранд ажиглалт хийсэн ч санал авах ажиллагааны нээлт, санал хураалт, санал тоолох ажиллагаанд системчилсэн ажиглалт хийгээгүй болно.

АИХЭГ-ын САТХ нь сонгууль ажиглах урилга илгээсэн эрх бүхий байгууллагууд болон хамтран ажиллаж, туслалцаа үзүүлсэн Гадаад хэргийн яам, Сонгуулийн ерөнхий хороонд талархал илэрхийлж байна. Мөн бусад төрийн байгууллагууд, улс төрийн намууд, нэр дэвшигчид, хэвлэл мэдээллийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагын төлөөлөгч нарт хамтран ажилласанд гүн талархал илэрхийлье.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбогдоно уу:

- Лолита Сигане, АИХЭГ-ын САТХ-ны Тэргүүн, Улаанбаатар хот (+976 8858 0942);
- Катя Андрус, АИХЭГ-ын Хэвлэлийн төлөөлөгч, Варшав хот (+48 609 522 266); эсхүл
- Кеара Касталдо, АИХЭГ-ын Сонгуулийн зөвлөх, Варшав хот (+48 603 638 999).

АИХЭГ-ын САТХ-ны хаяг:

Пума Империл зочид буудал, 4 давхар
Их сургуулийн гудамж, Улаанбаатар 14200, Монгол Улс
Утас: +976 8031 7003; цахим хаяг: office@odihr.mn